

ЗӨВШӨӨРӨВ:  
СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН  
ДАРГА, ХУРАНДАА Б. ТАМИР

ШШГЕГ-ЫН ХАРЪЯА СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГА

**ТҮЛШ ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: ТҮЛШ ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ШШГЕГСХТ/20200103

УЛААНБААТАР ХОТ

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.02.21

Тендер шалгаруулалтын дугаар: ШШГЕГСХТ/20200102/

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хоол хүнсний бүтээгдэхүүн** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь **цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын** дагуу зохион байгуулж байна.

Төсөвт өртөг: **17.493.000** төгрөг

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

**Багц-1: Түлш шатахуун**

Үнийн саналыг **2020 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2020 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 11-р хороо

**ШШГЕГ-ын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага**

Утас:80100411, 89092442

Цахим хуудас: [tender.gov.mn](http://tender.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь, төсөв;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) ТШӨХ-т заасан бусад шаардлагатай мэдээлэл
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт орлолцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ
  - 4.2 Тендерт орлолцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3 Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шат ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захийлагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4 Тендерт оролцогч нь тендерийн хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу нэн гэрээ бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн бусад үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны

нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

**6. Алдааг залруулах**

- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна.
- а. Тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ.
  - б. Үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтадзаасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна.
  - в. Нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаар нэгж үнэд аравтын ороны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна
- 6.2 Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны  
холбогдох заалт  
ТӨӨЗ 1.1

**А. Ерөнхий зүйл**

Захиалагч нь: **ШШГЕГ харьяа СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН  
ТУСГАЙ БАЙГУУЛЛАГА**

ТӨӨЗ 1.1

Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар:  
**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Сургалт  
хүмүүжлийн тусгай байгууллагын хүнсний материал  
нийлүүлэх тендер ШШГЕГСХТ20200102**

ТӨӨЗ 1.2

Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий  
багцуудаас бүрдэнэ:  
**Багц-1: Түлш шатахуун- 17,493,000 төгрөг**

ТӨӨЗ 2.1

Санхүүжилтийн эх үүсвэр нь: **Улсын төсвийн хөрөнгө**  
Нийт төсөвт өртөг: **17,493,000 төгрөг.**

**Б. Тендерийн баримт бичиг**

ТӨӨЗ 8.1

Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга  
авах хаяг:

**Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 11-р хороо Сургалт  
хүмүүжлийн тусгай байгууллага**  
**Утас:80100411**

ТӨӨЗ 8.1

**Цахим хуудас: tender.gov.mn**

Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг  
хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн  
хугацаанаас ажлын 6 хоногоос багагүй байна.

**В. Тендер бэлтгэх**

ТӨӨЗ 11.1

Тендерийг **Монгол хэл** дээр бэлтгэнэ.

ТӨӨЗ 12.1 (ё)

Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт  
хавсралтаар ирүүлнэ.Үүнд:

**Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар  
баталгаажуулсан/**

**Татварын албаны тодорхойлолт**

**Банк, санхүүгийн байгууллагаас хугацаа хэтэрсэн өр  
төлбөргүй эсэх тодорхойлолт**

**Харилцагч банкны харилцах дансны хуулга /сүүлийн  
зургаан сараар/**

**Шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны  
тодорхойлолт,**

– **Үйлдвэрлэгчийн гаргасан техникийн тодорхойлолт болон фото зураг.**

**Бараа нийлүүлэх хуваарь**

**Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх  
мэдээлэл**

□ 2017,2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан /Аудитын дүгнэлтийн хамт/,

□ Тодорхойлолтууд тендер зарласан хугацааны дараа байна.

ТОӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “ <b>зөвшөөрөхгүй</b> ”
ТОӨЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс-ийн хувилбар: <b>Incoterms 2010</b>
ТОӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)	<b>Бараа хүргэгдэх газар: Баянзүрх дүүрэг 11-р хороо Сургалт хүтүүжлийн тусгай байгууллага</b>
ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	<b>Бараа хүргэгдэх эцсийн цэг: Баянзүрх дүүрэг 11-р хороо Сургалт хүтүүжлийн тусгай байгууллага</b>
ТОӨЗ 15.9 (б) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан CIF үнээс үнэ байна. Энэ үнэнд НӨАТ, Гаалийн татвар багтсан байна.
ТОӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>тохируулахгүй тогтмол</b> байна.
ТОӨЗ 16.1	Тендерийн валют <b>төгрөг</b> байна.
ТОӨЗ 18.1 (а)	Барааг, хаанаас, хэрхэн нийлүүлэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох баримт, материалыг тендерийн хамт ирүүлнэ.
ТОӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b>2018, 2019 он.</b>
ТОӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <b>Шаардлагагүй</b>
ТОӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: <b>2018, 2019 оны борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна.</b>
ТОӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <b>Санал болгож буй нийт үнийн 50 хувиас багагүй дүнтэй тэнцүү өртөг бүхий ижил, төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр сүүлийн 2 жил /2018, 2019 он/ ядаж нэг удаа ажилласан байх ба нотлох гэрээ, актыг хавсаргана. Эсвэл хүнсний үйлдвэр, худалдааны чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх</b>
ТОӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <b>Шаардлагагүй</b>
ТОӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <b>Санал болгож буй нийт үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх бөгөөд түүнийг нотлох баримтыг ирүүлэх /үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, арилжааны банкны баталгаажсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий тодорхойлолт гэх мэт/</b>
ТОӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <b>2018, 2019 он</b>
ТОӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>Тооцно.</b>
ТОӨЗ 20.1	<b>Тендер нээснээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.</b>
ТОӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна хуулбар хувь ирүүлэх шаардлагагүй.
Г. Тендер ирүүлэх	
ТОӨЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:

Огноо: **2020 оны 03-р сарын 02-ны өдөр**

Цаг: **10 цаг 00 минут**

**Д. Тендерийг нээх, үнэлэх**

**ТӨЭЗ 28.1**

Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:

**Баянзүрх дүүрэг 11-р хороо Сургалт хүтүүжлийн тусгай  
байгууллага**

**Утас:80100411 89092442**

**Цахим хуудас: [tender.gov.mn](http://tender.gov.mn)**

Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:

Огноо: **2020 оны 03-р сарын 02-ны өдөр**

Цаг: **10 цаг 30 минут**

**Дөрөв: Техникийн тодорхойлолт**

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ХАРЬАА СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ  
БАЙГУУЛЛАГА**

№	Барааны нэр төрөл	Х/нэгж	Тоо хэмжээ	Тавигдах шаардлага	Тайлбар
<b>Багц 1: Түлш шатахуун</b>					
1	A-92	Литр	9507	Чанарын сертификаттай байх - Олон улсын стандартад нийцсэн	
<b>Нийт мөнгөн дүн</b>			<b>17,493,000</b>		